



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/287

Булган сум

┌ Инженер геологийн судалгааны гэрээ ┐
байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.2, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоолын хавсралтын 2 дугаар заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2014 оны 56 дугаар тушаалаар баталсан “Барилгын инженер геологийн ажлын жишиг үнэ БД 81-117-13” нормыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын 4 дүгээр баг Цэвэр усан хангамжийн нэгдсэн системийг шинээр байгуулах ажлын зураг төслийн өмнөх инженер геологийн судалгааны ажлыг 13,403,500 (арван гурав сая дөрвөн зуун гурван мянга таван зуу) төгрөгөөр “Лэнд Тэст” ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Инженер геологийн судалгааны ажлын явцад байнгын хяналт тавьж магадлалаар хянагдсан инженер геологийн судалгааны тайланг хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Дээрх ажлын санхүүжилтийг тухайн төсөл арга хэмжээний батлагдсан төсвөөс гэрээнд заасан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

6323010278